



“БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ” ХЭМЭЭХ УХАГДАХУУНЫГ T-LAB ПРОГРАММААР ШИНЖСЭН ҮР ДҮН

Б.Баярчимэг^а, С.Батхуяг^б, Б.Жадамба^в

^аМУБИС-Багшийн сургууль, багш, магистр;

^бМУБИС-Багшийн сургууль, ахлах багш, доктор;

^вМУБИС-Боловсрол судлалын сургууль, зөвлөх профессор, академич

Холбоо барих зохиогч: batkhuyag@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2024.08.25

Хянагдсан: 2024.09.20

Зөвшөөрсөн: 2024.10.25

Хураангуй

Гадаад, дотоодын тайлбар толь, эрдэмтдийн 50 гаруй бүтээл, цахим хүрээнд тусгагдсан “Байгальд ээлтэй” хэмээх ойлголт, ухагдахууны гарваль шинж, тодорхойлолт, тайлбар зэргийг баримт бичиг шинжилгээний “T-LAB 10 tools for text Analysis” программаар шинжлэн судалж, “хүрээлэн буй орчин” (environment)-той статистик ач холбогдолтой болохыг тогтоолоо. Түүний үндсэн дээр “Байгальд ээлтэй” хэмээх ухагдахуун нь нүүдэлч Монголчуудын уламжлалт соёлын ген болох амь ухагдахуунуудын нэг юм байна” гэсэн санаа дэвшүүлсэнд энэхүү судалгааны ажлын онцлог оршино. Судлагдахууныг дээрх программын дагуу шинжихэд “Байгальд ээлтэй” гэсэн ухагдахуун нь “хүрээлэн буй орчин”, “бүтээгдэхүүн”, “хор хөнөөлгүй”, “утга”, “хамаарал”, “байгалийн нөөц”, “бохирдол”, “хохирол”, “цаг хугацаа”, “практик”, “загвар шийдэл”, “ногоон”, “нөлөөлөл”, “тогтвортой байдал” зэрэг үгтэй холбоо хамааралтай байна. “Байгальд ээлтэй” гэдэг нь бүх судлагдахууны хүрээнд авч үзэх, хэрэгжүүлэх өргөн ойлголт тул тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад чухал нөлөөтэй. Сүүлийн үед олон улсын чиг хандлага болсон хэдий ч гаргаж авсан үр дүнгээ шинжлэн, байгальд ээлтэй ухагдахууныг Монголчуудын уламжлалт байгальд хандах хандлагын үүднээс томъёолон хэлэлцүүлсэн. Цаашид ээл, байгальд ээлтэй, байгальд ээлтэй хандлага зэргийг гүнзгийрүүлэн судлахын тулд монголчуудын уламжлалт байгаль хамгаалах арга, бөө мөргөлийн гүн ухааны хүрээнд бүтээсэн амь ухааны нарийвчлан шинжлэх шаардлагатай.

Түлхүүр үг

Байгальд ээлтэй, контент анализ, хүрээлэн буй орчин, тогтвортой байдал

Удиртгал

Сүүлийн жилүүдэд “Байгальд ээлтэй” гэсэн нэр томъёо олон нийтэд гүнзгий нэвтэрч, энэ нь тогтвортой байдал, байгаль хамгаалал, ногоон туршлагын гол ойлголт болсоор байна. Өргөн тархсан хэдий ч “Байгальд ээлтэй” гэсэн ухагдахуун нь олон талт, өөр өөр нөхцөл, байгаль, нийгмийн салбарыг хамардаг. Энэхүү хувьсах чанар нь уг үзэл баримтлалын үндсэн хэмжигдэхүүн болон түүнийг тухайн зүйлд хэрхэн тусгасан болохыг мэдэхийн тулд түүнийг системтэй, нарийн судлах шаардлагатайг онцолж байна.

Энэхүү судалгаа нь хэл шинжлэл, статистик, графикийн цогц хэрэглүүр болох T-LAB программ хангамжийг ашиглан, толь бичиг, цахим орчны хүрээнд “Байгальд ээлтэй” гэсэн ойлголтыг шинжлэв. T-LAB-ийн сэдэвчилсэн кластер, хавсарсан тохиолдлын дүн шинжилгээ, семантик сүлжээний судалгаа зэрэг текстийн шинжилгээг ашигласнаар “Байгальд ээлтэй” гэсэн утгыг олон талаас нь задалсан. “Байгальд ээлтэй” гэсэн ухагдахууны цаад мөн чанарыг тайлж, илүү тодорхой дүр зургийг гаргах зорилготой. Ecologically friendly гэдэг үгийн товчлол нь eco-friendly юм.

- Байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх эсвэл наанадаж, байгаль орчинд хохирол учруулахгүй байх [<https://www.dictionary.com/browse/eco-friendly> British dictionary definitions for ecofriendly]
- Байгальд ээлтэй гэдэг нь “байгаль орчинд хор хөнөөл багатай эсвэл огт нөлөөлөхгүй байхаар төлөвлөж боловсруулагдсан, бүтээгдсэн” гэсэн үг юм. [Cambridge dictionary]
- Eco-friendly Экологид ээлтэй гэдэг нь шууд утгаараа дэлхийд ээлтэй, байгаль орчинд хоргүй гэсэн үг юм (Johnson, 1995) Энэ нэр томъёо нь ихэвчлэн ногоон амьдралд хувь нэмэр оруулах бүтээгдэхүүн, ус, эрчим хүч гэх мэт нөөцийг хэмнэхэд тусалдаг зан үйлийг хэлнэ. Байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн нь агаар, ус, газрын бохирдолд хувь нэмэр оруулахаас сэргийлдэг. Иргэд байгалийн нөөцийг хэрхэн ашиглаж байгаагаа илүү ухамсарлаж, байгальд ээлтэй дадалтай болох боломжтой.

Монголчуудын хүн, байгаль хоёрын хүйн холбоот сэтгэлгээний төвд орших “ээл” хэмээх тулгуур ойлголтыг нарийвчлан авч үзэж, ээлтэй байх, байгальд ээлтэй хандлагын цаад мөн чанарыг утга, үүрэг, ач холбогдол, үнэ цэн талаас нь задлан шинжилсэн. Ялангуяа, монголчууд хүнийг тодорхойлохдоо нүднээ харагдаж буй мэдлэг, чадвараас илүү хүний дотоодод буй нандин чанар, сэтгэл, хандлагыг эрхэмлэдэг уламжлалт уугуул ухааныг эш болгон авч үзсэн юм.

Байгаль - 1. Байгаа бүх сав, шим ертөнц 2. Үзэмж

Ээл - 1. Алив юманд тус дэм болох сайны хувь, 2. Хор хөнөөлгүй, сайн сайхан, 3. Дулаан бүлээн

Ээлтэй - Ээл ихтэй, ивээлтэй (Сумъяабаатар, Б. Балдан, Л. ба бусад. 2008)

Байгальд ээлтэй (eco-friendly) - байгаль орчинд хор хөнөөлгүй (dictionary.com. 2015)

Баримт бичиг шинжилгээний “T-LAB 10 tools for text Analysis” программ нь эрдэм шинжилгээний туршилт судалгаа, онолын болон практик амьдралд өргөн хэрэглэгдэж байна. “Байгальд ээлтэй” гэсэн ухагдахууныг тодорхойлсноор бодлого боловсруулагчид, боловсролын байгууллагын судлаачид, багш, суралцагч,

байгаль хамгаалагч, байгаль орчны идэвхтэн, бизнес эрхлэгч, борлуулагч болон хэрэглэгчдэд илүү мэдээлэл өгч, дэмжлэг үзүүлэн, тогтвортой байдлыг практикт хэрэгжүүлэхэд нөлөөтэй.

Байгальд ээлтэй хандлагад холбогдох “Байгальд ээлтэй хандлагатай иргэн” гэсэн ойлголт нь хүн бүрийг суралцагч, тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэгч иргэн бэлтгэхийг чухалчилж буй энэ цаг үед шинэ санаа, шинэ томъёоллыг сургалт, судалгаанд хэрэглэхийг шаардаж байна.

Байгальд ээлтэй хандлагатай иргэн - Амьтай ба амьгүй байгалийн өөрөө бий болсон, жам ёсны хийгээд өөрөө боловсрох ёсыг журамлан дагадаг болсон иргэн (Жадамба, Б. 2021)


Байгаль ээлтэй хандлага (Eco-friendly attitude) нь байгальд ээлтэй зан үйлд эерэгээр нөлөөлдөг. Байгаль ээлтэй хандлага нь байгаль орчныг хамгаалах үнэлэмжийн талаарх тухайн хүний танин мэдэхүйг хэмжихэд чиглэгддэг. Энэ нь байгальд ээлтэй зан үйлийн урьдчилсан нөхцөл юм. Учир нь тухайн хүн хүрээлэн буй орчныг сайжруулах талаар тодорхой алхам хийхээс өмнө хүрээлэн буй орчинд ээлтэй хандлагаа илэрхийлдэг. Байгаль ээлтэй зан үйл нь байгаль орчныг хамгаалах талаар тодорхой алхам хийхэд бэлэн байгаа эсэхийг илтгэдэг. Байгальд ээлтэй хандлага нь байгальд ээлтэй зан үйлд хөтөлдөг. Байгаль орчны ойлголт мэдлэг нь хүрээлэн буй орчин, түүнд тулгарч буй асуудлын талаар хөндөж тавьдаг. Байгаль орчны өндөр мэдлэгтэй хүн хүрээлэн буй орчны ерөнхий нөхцөлийг сайжруулахын тулд хувь хүний болон байгууллагын түвшинд хүчин чармайлт гаргах шаардлагатайг ойлгодог. (Eco Friendly Attitude Impacts Eco Friendly Behaviour, 2017)

Судалгааны арга зүй

Дээрх судлагдахуун дотроос байгальд ээлтэй гэсэн англи хэл дээрх тодорхойлолтуудыг түүвэрлэн, T-LAB 10 программд арга зүйн өгөгдөл болгон бэлтгэж, түүнтэй холбогдох ухагдахууны давтамж, уялдаа холбоо, тэдгээрийн статистик ач холбогдлыг тооцоолон гаргасан болно. Энэхүү судалгаа нь “Байгальд ээлтэй” гэсэн хүрээлэн буй орчны тогтвортой байдал, байгальд ээлтэй туршлагын талаар багтаасан олон талт ойлголтыг судлахын тулд холбогдох тодорхойлолтуудад дүн шинжилгээ хийсэн. Текстүүдийг сонгох шалгуур нь “Байгальд ээлтэй” түлхүүр үг болон холбогдох нэр томъёо (жишээлбэл, “тогтвортой”, “ногоон”, “ээлтэй”)-нд үндэслэсэн. Эхний алхам нь цуглуулсан тодорхойлолтуудыг T-LAB программаар боловсруулах байв. Энэ үйл явц нь өгөгдлийн цэг, таслал, хамааралгүй мэдээллийг устгах замаар өгөгдлийг цэвэрлэх, мөн өгөгдлийн нийцлийг хангахын тулд нэр томъёог хэвийн болгох зэрэг багтсан. T-LAB-ийн сэдэвчилсэн кластерын функцийг ашиглан хийсэн бөгөөд энэ нь нийтлэг утгад тулгуурлан, текстийн сегментүүдийг бүлэглэж, “Байгальд ээлтэй” ойлголтын хүрээнд давамгайлсан нэр томъёог тодорхойлох юм. Судалгааны үр дүнг байгаль орчны тогтвортой байдал болон “Байгальд ээлтэй” ойлголтын талаарх тодорхойлолтуудын хүрээнд тайлбарлав.


Судалгааны үр дүн

Бид T-LAB 10 программд оруулан, боловсруулалт хийснээр “Байгальд ээлтэй”




“Байгальд ээлтэй” төвт үгэн сүлжээ, түүний хүрээний ухагдахуунуудын давтамжийг дээрх байдлаар үүсгэж байна.

Зураг 3. “Байгальд ээлтэй” уялдаа холбоо



“Байгальд ээлтэй” гэсэн ойлголт нь хүрээлэн буй орчин, бүтээгдэхүүн, хор хөнөөлгүй гэдэгтэй, харин “хүрээлэн буй орчин” нь тэдгээрээс гадна дизайн, бүтээгдэхүүн, хохирол, хор хөнөөл гэдэгтэй шууд хамааралтай байна. Харин дам хамаарал нь “Байгальд ээлтэй” гэсэн ойлголтын хувьд дизайн, хохирол, тогтвортой байдал, илүүг сонгох, практик, багасгах, хор хөнөөл гэдэгтэй, “хүрээлэн буй орчин” нь тогтвортой байдал, байгалийн нөөц, илүүг сонгох, практик, багасгах зэрэгтэй холбогдож байна.

Зураг 4. Байгальд ээлтэй (eco-friendly) ба тогтвортой байдал (sustainability)-ын харилцан хамаарал



Дүгнэлт

“Байгальд ээлтэй” талаарх англи, монгол тодорхойлолтуудад Т – LAB шинжилгээ хийн, үр дүнд түшиглэн, дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Баримт бичиг шинжилгээний “T-LAB 10 tools for text Analysis” программын дагуу шинжин үзэхэд байгальд ээлтэй нь хүрээлэн буй орчин, бүтээгдэхүүн, хор хөнөөлгүй, утга, хамаарал, байгалийн нөөц, бохирдол, хохирол, цаг хугацаа, практик, дизайн, ногоон, нөлөөлөл, тогтвортой байдал зэрэгтэй хамгийн өндөр давтамжтай байна. “Байгальд ээлтэй” гэдэг нь бүх судлагдахууны хүрээнд авч үзэх, хэрэгжүүлэх өргөн ойлголт тул тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад чухал нөлөөтэй.
- Сүүлийн үед олон улсын чиг хандлага болоод байгаа хэдий ч илрүүлсэн үр дүнгээ задлан шинжилж, байгальд ээлтэй ухагдахууныг Монголчуудын уламжлалт байгальд хандах хандлагын үүднээс томъёолон хэлэлцүүлсэн. Цаашид ээл, байгальд ээлтэй, байгальд ээлтэй хандлага зэргээр гүнзгийрүүлэн судлахын тулд монголчуудын уламжлалт байгаль хамгаалах арга, бөө мөргөлийн гүн ухааны хүрээнд бүтээсэн амь ухааныг нарийвчлан шинжлэх шаардлагатай.

Ном зүй

Батхуяг, С. Баярчимэг, Б. Дауренбек, Ш. (2022). Бага боловсролын байгалийн ухааны монгол - англи нэр томъёоны тайлбар толь. Улаанбаатар.

Бямбацэрэн, Г. Наранцэцэг, Д. Ганболд, Д. ба бусад. (2024). Бага боловсрол толь бичиг. Улаанбаатар.

RESULTS OF ANALYZING THE CONCEPT OF “ECO-FRIENDLY” USING T-LAB SOFTWARE

^aBayarchimeg B, ^bBatkhuuyag S, ^cJadamba B

^aMaster, Lecturer, Teachers School, MNUE;

^bPh.D., Lecturer, Teachers School, MNUE;

^cAcademician, Consulting professor, School of Educational Studies, MNUE

Corresponding author: batkhuyag@msue.edu.mn 

Abstract

The study analyzed foreign and domestic dictionaries, over 50 works by scholars, the concept of “eco-friendly” as represented in the digital space, the origin, definition, and description of this concept, using the “T-LAB 10 tools for text Analysis” software for document analysis. It was found that the concept of “eco-friendly” has statistical significance in relation to the “environment”. The distinctive feature of this research work is the proposal that the concept of “eco-friendly” is one of the core concepts or “genes” of the traditional culture of the nomadic Mongolians.

According to the analysis using the above software, the concept of “eco-friendly” is related to words such as “environment”, “product”, “non-harmful”, “meaning”, “relation”, “natural resources”, “pollution”, “damage”, “time”, “practice”, “model solution”, “green”, “influence”, “sustainability”. The concept of “eco-friendly” is a broad one that should be considered and implemented across all domains, and is therefore crucial for achieving sustainable development goals.

Although this concept has become a recent international trend, the study analyzed the findings from the perspective of the traditional Mongolian approach to nature. Further in-depth studies are needed to explore the notions of “care”, “eco-friendly attitude”, and “eco-friendly approach” within the framework of the traditional Mongolian spiritual and shamanic knowledge of the “science of life”.

Keywords

Eco-friendly, Content analysis, Environment, Sustainability